



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Чулуут ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2023/05/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Архангай аймаг
Чулуут сум
2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

Бизкон аудит ХХК Архангай дахь салбар

Утас: 85116555 Цахим хаяг: ankha964@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэл.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал.....	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
5.1 Шилэн дансны мэдээлэл	11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
8. Аудитын илрүүлэлт	13
8.1 Зөвлөмж	
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж Ахуй Нэгжийн Орлогын Албан Татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

1. Аудитын санал дүгнэл



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.03.15 № 124
танай _____-ны № _____-т

“ЧУЛУУТ АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ч.ЧИМЭДДЭЛЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чулуут ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Чулуут ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад асуудал

Чулуут ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ тайлант онд Чулуут сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 02 сарын 28 өдрийн 16 тоот тогтоолоор талбай түрээслэх үн тарифыг тогтоолгосон бөгөөд үйлдвэрийн газрын дүрмийн зургаадугаар зүйлд заасны дагуу үйлдвэрийн газрын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулж биелэлтийг хангуулаагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9,423.95	57,354.96
1.1.2	Дансны авлага	2,954,600.00	105,000.00
1.1.6	Бараа материал	2,563,200.00	2,132,745.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,527,223.95	2,295,099.96
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,132,642,865.33	1,108,488,329.66
1.2.9	Бусад үндсэн хөрөнгө	-	911,970.00
1.2.10	Эргэлтийн бүс хөрөнгийн дүн	1,132,642,865.33	1,109,400,299.66
1.30	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,138,170,089.28	1,111,695,399.62
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	10,424,864.44	1,683,731.94
2.1.1.1	Дансны өглөг	5,320,000.00	1,289,545.00
2.1.1.3	Татварын өр	1,133,110.00	394,186.94
2.1.1.4	ЭМНД -ийн шимтгэлийн өглөг	3,971,754.44	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,424,864.44	1,683,731.94
2.20	Өр төлбөрийн нийт дүн	10,424,864.44	1,683,731.94
2.3.1	Эздийн өмч	1,261,748,800.00	1,261,748,800.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	19,240,890.00	19,240,890.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(153,244,465.16)	(170,978,022.32)
2.3.10	Өмнөх үеийн ашиг /алдагдал/	(153,244,465.16)	(153,364,465.16)
2.3.11	Тайлант үеийн ашиг/алдагдал/		(17,613,557.16)
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,127,745,224.84	1,110,011,667.68
2.40	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,138,170,089.28	1,111,695,399.62

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/ Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		
1.1	Түрээсийн орлого	29,654,000.00	39,661,400.00
1.2	Бусад орлого	5,524,900.00	9,257,050.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	58,822,494.11	66,532,007.16
9.1	Ажиллагчдын цалингийн зардал	27,540,000.00	24,275,878.69
9.2	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	3,318,600.00	2,917,541.00
9.3	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	108,000.00	-
9.4	Томилолтын зардал		140,000.00
9.5	Бичиг хэргийн зардал		113,000.00
9.6	Шуудан холбооны зардал	2,753,218.00	-
9.7	Ашиглалтын зардал	3,445,473.00	13,992,321.80
9.8	Засварын зардал	5,952,727.00	-
9.9	Элэгдэл, хорогдлын зардал		23,242,565.67
9.10	Эмийн зардал	1,588,273.00	500,000.00
9.11	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	1,158,909.00	130,000.00
9.12	Шатахууны зардал	4,732,815.00	698,000.00
9.13	Банкны үйлчилгээний холбогдох зардал	910,000.00	-
9.14	Бусад болон зээлийн хүүгийн зардал	1,811,913.15	522,700.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(23,643,594.11)	(17,613,557.16)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(23,643,594.11)	(17,613,557.16)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(23,643,594.11)	(17,613,557.16)
24	Орлогын нийт дүн	(23,643,594.11)	(17,613,557.16)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
№	Үзүүлэлт	Халаасны хувьцаа	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
9	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,261,748,800.00	19,240,890.00	(153,244,465.16)	1,127,745,224.84
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(120,000.00)	(120,000.00)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(17,613,557.16)	(17,613,557.16)
17	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,261,748,800.00	19,240,890.00	(170,978,022.32)	1,110,011,667.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн	
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	38,609,570.00	51,648,050.00	
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	38,609,570.00	39,661,400.00	
1.1.5	Үйл ажиллагааны орлого	-	9,257,050.00	
1.1.6	Бусад мөнгөн орлого	240,000.00	2,729,600.00	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	37,596,173.00	51,600,118.99	
1.2.1	Ажиллагчдад төлсөн	20,979,596.00	20,521,616.13	
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,488,875.00	9,629,755.00	
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,360,030.00	313,000.00	
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	5,395,672.00	8,597,321.80	
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		9,383,000.00	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	5,372,000.00	1,752,726.06	
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	500,000.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-	902,700.00	

1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,013,397.00	47,931.01
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,013,300.00	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,013,300.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(1,013,300.00)	0.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	97.00	47,931.01
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,423.95
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,423.95	57,354.96

Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөг/

Д/Д	Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	35,178,900.00	52,026,000.00	48,918,450.00	3,107,550.00	94.0
2	а/ Түрээсийн орлого	29,654,000.00	46,878,000.00	39,661,400.00	7,216,600.00	84.6
3	б/ Бусад орлого	5,524,900.00	5,148,000.00	9,257,050.00	(4,109,050.00)	179.8
4	Нийт зардал	58,822,494.11	52,026,000.00	66,532,007.16	(14,506,007.16)	127.9
6	Татварын өмнөх ашиг /алдагдал/	(23,643,594.11)	360,500.00	(17,613,557.16)	17,974,057.16	
11	в/НДШ	3,318,600.00		5,658,000.56	(5,658,000.56)	
12	г/Хүн амын орлогын албан татвар	-		1,013,803.00	(1,013,803.00)	
16	Нийт ажиллагсдын тоо	4.00	6.00	6.00	-	100.0
17	Нийт цалингийн сан	30,858,600.00	34,081,500.00	27,193,419.69	6,888,080.31	79.8
19	Нийт авлага	2,954,600.00		105,000.00	(105,000.00)	
21	Нийт өглөг	10,424,864.44		1,683,731.94	(1,683,731.94)	

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах 2 албан шаардлага, хүргүүлээ.

3.1 Албан шаардлага

3.1.1 10, 11, 12 сарын 3 хүний НДШ 394.0 мянган төгрөгийг тайлагнаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх; 2/шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх; 3/нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах;4/нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд уг зөрчлийг арилгах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын тайлангаа засварлаж шимтгэлийг шивэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3.2 Хариуцлага тооцуулах албан шаардлага

3.2.1. Тус байгууллагын нягтлан бодогч нь Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах өмнөх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.

Иймд нягтлан бодогч Б.Даваасүрэнд Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д " тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 10.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хүргүүлээ.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, сургалтын зардлыг хэмнэж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/									
							Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Чулуут Ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ	АРА-2022/227/НА-СТА-ОНА	10, 11, 12 сарын 3 хүний НДШ 394.0 мянган төгрөгийг тайлагнаагүй	-	1	-					1	394.0				
ДҮН				-							1	394.0				
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Чулуут Ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ	АРА-2022/227/НА-СТА-ОНА	Шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллийг шилэн дансанд бүрэн байршуулаагүй 59 мэдээллийг хугацаа хоцроосон, 11 мэдээллийг оруулаагүй		1	-							1			
ДҮН				-	2	-							1			
НИЙТ ДҮН				-	2	-							1			